



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/316

Булган сум

**Аяныг зохион байгуулахад шаардагдах
зардалд хөрөнгө гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Инновацын тухай хуулийн 11 дүгээр зүйл, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/32 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шинжлэх ухаан, технологи, инновацын ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, орон нутагт тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухаанд тулгуурлан шийдвэрлэх, мэдээллийн технологийн боломжийг таниулах, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлд хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор зохион байгуулж буй “Шинжлэх ухаан, технологи, инновацыг орон нутагт нутагшуулъя” аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.


2. Зардлын 3,500,000 (Гурван сая таван зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн “Шинэ ирээдүй” хөтөлбөр төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



05 дугаар сарын 02-ны/ний өдрийн А/316 дугаар захирамжийн хавсралт



“ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦЫГ ОРОН НУТАГТ НУТАГШУУЛЪЯ”
АЯН ЗОХИОН БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	Үдийн цай	250	8,000	2,000,000
2	Кофе	1 хайрцаг	103,500	103,500
3	Ус, ундаа	180	2240	403,200
6	Хоол	15	33,100	496,500
7	Хэвлэлийн зардал	10м ²	10,580	105,800
10	Гарын бэлэг	8	48,875	391,000
Нийт дүн				3,500,000